

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 29 ДҮГЭЭР ХУРАЛДААНЫ ТОЙМ

Хуралдаан 2013 оны 11 дүгээр сарын 01-ий өдрийн 13 цаг 00 минутад эхэлж, 14 цаг 36 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 36 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Удирдах албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчдад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none">- Барилга, хот байгуулалтын яамны Стратеги, төлөвлөлтийн газрын дарга- Зам тээврийн яамны Стратеги, төлөвлөлтийн газрын дарга- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Барилга, хот байгуулалтын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд Гүлхүүгийн Мэргэнбаярт дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Зам, тээврийн яамны Стратегийн</p>

		<p>бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд Сайнбилэгийн Гэрэлмаад дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батзаяад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “б”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Гочоогийн Нарангэрэлд дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Отгонжаргалд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Энхжаргалын 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 1/4007 тоот албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Төрийн</p>

		<p>албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 11 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулахаар тогтлоо.</p>
3	<p>Говьсүмбэр, Дундговь аймагт зохион байгуулсан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 56 дугаар зүйлд заасны дагуу Говьсүмбэр, Дундговь аймагт зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Говьсүмбэр, Дундговь аймгуудад 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 15 иргэнийг нэг, хоёрдугаар хавсралтаар “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 3 иргэнийг гуравдугаар хавсралтаар “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс дөрөв, тавдугаар хавсралтад нэр дурдсан хамгийн өндөр оноо бүхий 9 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс зургадугаар хавсралтад нэр дурдсан хамгийн өндөр оноо бүхий 3 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх.</p>

		<p>3. Энэхүү тогтоолын 2 дахь заалтаар нэр дэвшүүлсэн 12 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Говьсүмбэр, Дундговь аймаг дах Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн даргад үүрэг болгоах.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Өвөрхангай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Өвөрхангай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Цэрэнтүндэвийн Ганболдыг томилох.</p> <p>2. Салбар зөвлөлийн ажлыг хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн дарга Ц.Ганболдод даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

